



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 23 сарын 23 өдөр

Дугаар A/30

Мандалговь

Ш.Отгонжаргалыг Гурвансайхан сумын
Ерөнхий боловсролын сургуулийн захирлын
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын Төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Шаравжамц овогтой Отгонжаргал 91.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Ш.Отгонжаргалын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын
03.-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



**Гурван сайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын
албан тушаалд нэр дэвшүүлсэн Ш.Отгонжаргалын тухай дүгнэлт**

1. Ш.Отгонжаргал нь 1975 онд Дундговь аймгийн Луус суманд төрсөн. 48 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2004-2009 онд МУБИС-ийн Бага боловсролын багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. 1993-1996 онд Луус сумын ЕБС-д бага ангийн багш, 2002-2003 онд Өндөршил сумын ЕБС-д бага ангийн багш, 2003 оноос хойш Луус сумын ЕБС-д бага ангийн багш сургалтын менежерээр тасралтгүй ажиллаж байна.
4. Ш.Отгонжаргалын төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан зэргийг харгалзан Гурван сайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ